

## **МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗӨВЛӨМЖ**

### **Зөвлөмжийн зорилго, ач холбогдол**

Энэхүү зөвлөмжийн зорилго нь санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ) нар Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд өөрийн бизнесийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийг үнэлэх, улмаар эрсдэлийг бууруулах дотоод хяналтын хөтөлбөр боловсруулахад туслахад оршино.

Мэдээлэх үүрэгтэй этгээд (МҮЭ) өөрийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ заавал энэхүү зөвлөмжийг дагах шаардлагагүй бөгөөд өөрийн бизнесийн үйл ажиллагаанд тохирох эрсдэлийн үнэлгээний аргыг ашиглаж болно. Жишээлбэл, томоохон МҮЭ-үүд нь эрсдэлийн үнэлгээ хийх өөрийн гэсэн систем, аргачлалтай байж болно. Гол нь энэхүү аргачлал нь МУТСТ-тэй холбоотой хууль, журмын шаардлагыг хангасан байх ёстой.

### **Зөвлөмжийг хэн ашиглах вэ?**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тухай хуулийн 4.1.9-т заасан нотариатч, хуульч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нар өөрийн харилцагчтай холбоотой дараах ажиллагааг бэлтгэсэн, хийсэн, эсхүл оролцсон бол энэхүү гарын авлагыг ашиглана. Үүнд:

- үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;
- харилцагчийн хөрөнгийг удирдах;
- банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;
- компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах

### **Эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт, шаардлага**

ФАТФ-ын Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд үндэсний, салбарын, МҮЭ-ийн түвшинд МУТС эрсдэлийг үнэлэх шаардлагатай байдаг. Энэ хүрээнд МУТСТ тухай хууль, Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд тус тус заасны дагуу нийт МҮЭ өөрт учирч болох МУТС эрсдэлийг ойлгож, үр дүнтэй удирдах зорилгоор эрсдэлийг үнэлнэ. Эрсдэлийн үнэлгээний цар хүрээ, давтамж нь тухайн МҮЭ-ийн бизнесийн шинж чанар, хэмжээтэй уялдсан байна.

МҮЭ нь өөрт учирч болох МУТС эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан тухайн эрсдэлийг удирдах, бууруулахад чиглэсэн оновчтой арга хэмжээг багтаасан МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журам боловсруулна. Өндөр эрсдэлтэй тохиолдолд эрсдэлийг удирдах болон бууруулах нэмэлт арга хэмжээг дотоод хяналтын хөтөлбөрт тусгана.

МҮЭ нь өөрийн зохицуулагч байгууллагаас тавьж буй шаардлагын дагуу эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчлэх, эрсдэлийн үнэлгээний тайлангаа зохицуулагч байгууллагад тогтмол хүргүүлэх, хяналт шалгалтын явцад гаргаж өгөхөд бэлэн байдлаар хадгалах үүрэгтэй.

## **Эрсдэлийн үнэлгээ хийсний ач холбогдол**

ФАТФ-ын зөвлөмжийн дагуу МҮЭ нь МУТСТ үйл ажиллагааг эрсдэлд суурилсан зарчмаар хэрэгжүүлэх шаардлагатай. Эрсдэлд суурилсан зарчим нь МҮЭ-ийг зөвхөн эрсдэл багатай гүйлгээ хийх, үйл ажиллагаа явуулах, эрсдэл багатай үйлчлүүлэгчидтэй бизнесийн харилцаа тогтоох зэргээр хязгаарлах зорилгогүй. Харин эдгээр МҮЭ-ийн хязгаарлагдмал дотоод нөөцийг үр ашигтай хуваарилах замаар МУТС эрсдэлийн хариу арга хэмжээг үр дүнтэй удирдах, эрэмбэлэхэд туслах зорилготой юм. Эрсдэлийн үнэлгээг хийснээр мэдээлэх үүрэгтэй этгээд нь өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагч, газар зүйн байршил, суваг зэргийг тодорхойлж, тэдгээр өндөр эрсдэлтэй хэсэгт өөрийн нөөц бололцоог түлхүү хуваарилан, МУТС эрсдэлээс үр ашигтай урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

## **Эрсдэлийн үнэлгээ хийх шат дараалал**

### **1. Бэлтгэл шат**

Эрсдэлийн үнэлгээ хийхээс өмнө МҮЭ нь Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээ, Монгол улсын харилцан үнэлгээний тайлан, Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-аас гаргасан типологийн тайлан болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Мэргэжлийн холбоодоос гаргасан бусад гарын авлага, зааварчилгаатай танилцана. Ингэснээр МҮЭ нь үндэсний хэмжээнд гарч буй МУТС эрсдэлийг ойлгож, өөрийн байгууллагын түвшинд хийж буй эрсдэлийн үнэлгээндээ ашиглах юм. Түүнчлэн өөрсдийн үйл ажиллагаанд хамааралтай ФАТФ-ын зөвлөмжүүд, Монгол улсын МУТСТ-тэй холбоотой хууль, журамтай бүрэн танилцсан байна.

### **2. Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох шат**

МҮЭ-ийн үйл ажиллагаанд МУТС эрсдэл үүсгэх хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж, тодорхойлно. Үүнд:

#### **а. Бүтээгдэхүүн үйлчилгээ**

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн үзүүлж буй зарим бүтээгдэхүүн үйлчилгээ нь өөрийн онцлог шинж чанараас хамаарч МУТС илүү өндөр эрсдэлтэй байж болно. Тухайлбал харилцагчид нэрээ нууцлах боломж олгодог эсвэл их хэмжээний бэлэн мөнгө, валют ашигладаг бүтээгдэхүүн үйлчилгээ илүү эрсдэлтэй байна. Иймд бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэлийг үнэлэхдээ МҮЭ нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээний нарийн төвөгтэй байдал, үнэ цэнэ/хэмжээ, бүтээгдэхүүний ил тод байдлын түвшинг анхаарч үзэх шаардлагатай.

Аливаа бүтээгдэхүүн үйлчилгээг МУТС зорилгоор ашиглах боломжтой эсэхийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь нэрээ нууцлах боломжтой юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь таны харилцагчийг эцсийн өмчлөгчийг нуун далдлах боломж олгодог уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь таны харилцагчийн хөрөнгө, баялгийн эх үүсвэрийг нуун далдлах боломж олгодог уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь гуравдагч этгээд рүү төлбөр төлөх боломж олгодог үү?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь ихэвчлэн бэлэн мөнгө хүлээн авах, бэлэн мөнгөөр төлбөр төлөх боломжтой байдаг уу?

- Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээ, СМА болон бусад зохицуулах байгууллагаас гаргасан баримт бичигт тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээг МУТС өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь хил дамнан хөрөнгө, мөнгө шилжүүлэх боломж олгодог уу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь их хэмжээний гүйлгээг богино хугацаанд хийх боломж олгодог уу?
- Харилцагч нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн хараа хяналт багатайгаар тухайн бүтээгдэхүүн/үйлчилгээний тусламжтай гүйлгээ хийх боломжтой юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь маш өндөр дүнтэй гүйлгээ эсвэл хөрөнгө оруулалтын үнэ цэнэтэй юу?
- Бүтээгдэхүүн/үйлчилгээ нь ер бусын нарийн төвөгтэй байдаг уу?

#### **б. Бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэх хэлбэр, суваг**

Танай байгууллага харилцагчтай бизнесийн харилцаа тогтоох, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх хэлбэр нь МУТС эмзэг байдалд нөлөөлдөг. Сувгийн эрсдэлийг тогтоохдоо МҮЭ нь нүүр тулсан бус зайнаас бизнесийн харилцаа тогтоох, зуучлагч, дундын этгээд ашиглахтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Энэ төрлийн эрсдэлийг тогтооход МҮЭ бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн хүргэж байгаа нь чухал үүрэгтэй бөгөөд анх бизнесийн харилцаа тогтоохоос эхлээд цаашдын харилцаа хэрхэн явагдаж буйг анхаарах шаардлагатай. Харилцагч нь МҮЭ-ийн үйлчилгээг мөнгө угаалтын байршуулах шатанд ашиглаж байгаа тохиолдолд аливаа ер бусын, сэжигтэй үйлдлийг илрүүлэхэд илүү төвөгтэй болдог. Иймд тухайн харилцагчийг таньж мэдэх, баталгаажуулах, бизнесийн харилцааны зорилго зэргийг ойлгох нь маш чухал юм. Мөн дундын этгээд, төлөөлөгч, зуучлагч ашиглаж буй тохиолдолд харилцагчийн хэн болох, эцсийн өмчлөгч, хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тогтооход хүндрэлтэй байдаг.

Сувгийн эрсдэл үнэлэхдээ МҮЭ нь өөрийн бизнесийн бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх бүх сувгуудыг авч үзэх бөгөөд дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- Харилцагчийг таньж мэдэх үед өөрийн биеэр ирдэг эсэх. Үгүй бол:
  - МҮЭ нь зайнаас харилцагчийг таньж мэдэх үед баталгаатай эх үүсвэр ашигладаг эсэх
  - МҮЭ нь харилцагч бусдын хувийн мэдээлэл ашиглах, залилахаас урьдчилан сэргийлж, шаардлагатай арга хэмжээ авдаг эсэх
- Интернетээр бүтээгдэхүүн/үйлчилгээ үзүүлдэг эсэх
- МҮЭ нь харилцагчтай шууд бус харилцаатай эсэх (дундын зуучлагч этгээдээр дамжуулж)
- Бүтээгдэхүүн/үйлчилгээг төлөөлөгч эсвэл зуучлагчаар дамжуулан үзүүлдэг эсэх
- Бүтээгдэхүүн/үйлчилгээг хил дамнан бусад улс оронд үзүүлдэг эсэх

#### **в. Харилцагчийн төрөл**

Танай байгууллага ямар төрлийн харилцагчдад үйлчилгээ үзүүлдэгийг тодорхойлж, эдгээр нь мөнгө угаах зорилгоор хэр түгээмэл ашиглагддагийг үнэлнэ. Харилцагчдаа салбар, хэмжээ, төрлөөр нь ангилж болно (Ж нь хувь хүн, траст, ХХК, ХК г.м). Нийт харилцагчийн төрлөө тодорхойлохдоо танай байгууллага тодорхой салбар руу чиглэн үйл ажиллагаагаа явуулдаг эсэхийг авч үзэхээс гадна өөрийн цахим хуудас, сурталчилгаа, дотоод мэдээллийн систем зэргээс мэдээлэл авч болно.

Тодорхой харилцагч, хуулийн этгээд нь бизнесийн үйл ажиллагаа, ажил мэргэжил, хийх гүйлгээ зэргээс хамаарч МУТС эрсдэл өндөр байж болно. МҮЭ нь өөрийн харилцагчийн бүлгүүдийг тодорхойлж (харилцагчдаа салбар, хэмжээ, төрлөөр нь ангилж, бүлэглэж болно), тэдний хийж буй гүйлгээ, хаанаас гүйлгээг эхлүүлж байгаа, ямар төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ ашиглаж байгаа зэргийг үнэлнэ. Ингэснээр МҮЭ нь ямар төрлийн харилцагч нь өндөр, дунд, бага эрсдэлтэйг тодорхойлох боломжтой. Харилцагч, хуулийн этгээдийн жишээг доор харуулав.

- Гадаадын санхүүгийн байгууллагууд, тэр дундаа банкууд, мөнгө шилжүүлэх үйлчилгээ үзүүлэгчид (жишээлбэл, валют арилжаа, мөнгө шилжүүлэгч);
- Банк бус санхүүгийн байгууллагууд (жишээлбэл, мөнгөний үйлчилгээний бизнес; казино; үнэт цаасны брокер/дилерүүд; үнэт металл, чулуу, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч);
- Улс төрийн өндөр албан тушаалтан буюу улс төрд нөлөө бүхий этгээд (УТНБЭ), тэдний ойрын гэр бүлийн гишүүд, хамсаатнууд;
- Гадаадын корпорациуд болон дотоодын аж ахуйн нэгжүүд, ялангуяа оффшор компаниуд (дотоодын халхавч компани, эрсдэл өндөртэй улсад байрладаг хувийн хөрөнгө оруулалтын компани (PIC), олон улсын бизнесийн корпораци (IBC) г.м);
- Бэлэн мөнгө их эргэлддэг бизнесүүд (жишээлбэл дэлгүүр, ресторан, барааны дэлгүүр);
- Төрийн бус байгууллага, буяны байгууллагууд (гадаад, дотоодын);
- Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид (жишээ нь өмгөөлөгч, нягтлан бодогч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч);
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч.

МҮЭ нь шинэ болон одоо байгаа харилцагчдынхаа эрсдэлийг үнэлэхдээ дараах асуултуудыг асуух шаардлагатай. Үүнд:

- Траст эсвэл бусад төрлийн хуулийн этгээд үү?
- Эцсийн өмчлөгчийг тогтоосон уу?
- МУТСТ тухай хуулинд өндөр эрсдэлтэй харилцагч гэж заасан уу?
- Тохиолдлын чанартай эсвэл нэг удаагийн тодорхой хязгаараас давсан өндөр дүнтэй гүйлгээнд оролцдог уу?
- Санхүүгийн ямар нэг ашиг тусгүй хэр нь бизнесийн нарийн төвөгтэй бүтцийг ашигладаг уу?
- УТНБЭ мөн үү?
- Бэлэн мөнгө их эргэлддэг бизнес мөн үү?
- Авлига, хээл хахууль ихтэй бизнестэй холбоотой юу?
- Тайлбарлах боломжгүй, эх үүсвэрийг нь баталгаажуулахад хэцүү хөрөнгө, мөнгө байгаа юу?
- Нягтлан бодогч, хуульч эсвэл бусад мэргэжлийн хүмүүсээр дамжуулан бизнесээ явуулж байна уу эсвэл ийм этгээд анх зуучилж танилцуулсан уу?
- Ашгийн бус байгууллага мөн үү?
- Үндэсний болон салбарын эрсдэлийн үнэлгээ, СМА, бусад зохицуулагч байгууллагаас МУТС өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон уу?

#### **г. Газар зүйн байрлал**

МҮЭ-ийн комплаенсийн нэг чухал хэсэг нь өндөр эрсдэлтэй байж болзошгүй улс орон, газар зүйн байршлыг тодорхойлох юм. Харилцагч болон эцсийн өмчлөгч нь хаана байрладаг, үүсгэн байгуулагдсан, харилцагчийн хаашаа эсвэл хаанаас гүйлгээ илгээж,

хүлээн авч байгаа, бизнесийн үйл ажиллагаа нь ямар улс орнуудыг хамардаг гэх зэргээс хамаарч МҮЭ нь газар зүйн эрсдэлд орж байдаг.

Иймд МҮЭ нь өөрийн үйл ажиллагаа явуулж буй улс орон, харилцагчийн данс нээлгэж буй байршил, гүйлгээ хийж буй газар зэрэгтэй холбоотой үүсч болох эрсдэлийг ойлгож үнэлэх шаардлагатай. Гэхдээ газарзүйн эрсдэл нь дангаараа харилцагчийн болон гүйлгээний эрсдэлийн түвшинг тодорхойлохгүй. МҮЭ нь өөрийн харилцагч болон үйл ажиллагаа явуулж буй, гүйлгээ илгээж, хүлээн авч буй улс орон хоорондын хамаарлыг ойлгосноор эрсдэлийн үнэлгээг үр дүнтэй хийж чадна. Өндөр эрсдэлтэй газарзүйн байршил нь олон улсад болон дотоодод байж болох бөгөөд МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдал, суурь гэмт хэргийн түвшин, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, ил тод байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Мөн өндөр эрсдэлтэй бүс нутагт дараах улс орнууд хамаарч болно. Үүнд:

- МУТС-тэй тэмцэх тогтолцоо нь хангалтгүй улс орнууд;
- АНУ, Европын холбоо зэрэг томоохон бүс нутгийн санхүүгийн хориг арга хэмжээ, хязгаарлалт болон ижил төстэй арга хэмжээнд орсон улс орнууд;
- Найдвартай эх сурвалжаас авлига хээл хахууль болон бусад гэмт хэргийн үзүүлэлт өндөртэй гэж тодорхойлогдсон улс орнууд;
- Найдвартай эх сурвалжаас тухайн улс орон эсхүл бүс нутаг нь терроризмыг санхүүжүүлдэг, террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг эсхүл террорист бүлэглэл үйл ажиллагаа явуулдаг гэж тодорхойлогдсон улс орнууд
- Оффшор улс орнууд;
- Дотоодын өндөр эрсдэлтэй газарзүйн байршил.

Улс орны газарзүйн эрсдэлийг тодорхойлохдоо төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжийг ашиглаж болно. Үүнд:

- ФАТФ-ын эрсдэл өндөртэй болон стратегийн ноцтой дутагдалтай улс орны жагсаалт<sup>1</sup>
- ФАТФ-ын харилцан үнэлгээний тайлан
- Европын Холбооны мөнгө угаах болон татварын хар жагсаалт
- Базелийн мөнгө угаахтай тэмцэх индекс<sup>2</sup>
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн газар (UNODC)-ын тайлангууд
- Транспэрэнси Интернэшнлээс гаргасан авлигын төсөөллийн индекс<sup>3</sup>
- “Улс орнуудыг таньж мэдэх” тайлан<sup>4</sup>
- Итгэмжлэгдсэн, хараат бус хэвлэл мэдээллийн эх сурвалж
- НҮБ-ын хориг арга хэмжээ.

#### **д. Онцлог, хэмжээ, нарийн төвөгтэй байдал**

Байгууллагын явуулж буй үйл ажиллагааны цар хүрээ, нарийн төвөгтэй байдал нь МУТС эрсдэлд хэр өртөмтгий байхыг мөн тодорхойлдог. Тухайлбал бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх боломжтой бизнес нь зөвхөн банкны шилжүүлэг, карт ашиглах боломжтой бизнесээс илүү эрсдэлтэй байж болно. Зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг бол энэ нь хил дамнан нарийн төвөгтэй гүйлгээ хийх боломжтой байгууллагаас эрсдэл бага байх боломжтой. Иймд МҮЭ нь өөрийн дотоод тайлан мэдээнд үндэслэн үйл ажиллагааных нь аль хэсэг МУТС үйл ажиллагаанд өртөх боломжтойг тодорхойлох шаардлагатай.

<sup>1</sup> <https://www.fatf-gafi.org/en/countries/black-and-grey-lists.html>

<sup>2</sup> <https://index.baselgovernance.org/>

<sup>3</sup> <https://www.transparency.org/en/cpi/2022>

<sup>4</sup> <https://www.knowyourcountry.com/country-reports/>

### 3. Эрсдэлийг үнэлэх шат

Өөрийн бизнесийн үйл ажиллагаа, гүйлгээтэй холбоотой МУТС эрсдэлийн түвшинг тогтооходоо МҮЭ нь дээр тодорхойлсон МУТС эрсдэлийн хүчин зүйлсийг бүхэлд нь авч үзэх шаардлагатай.

#### А. Магадлал, үр дагаврыг тооцох

Эрсдэлийн түвшинг үнэлэх нэг арга нь тухайн эрсдэл тохиолдох магадлал (likelihood), эрсдэлийн үр дагавар (consequence)-ыг эрсдэлийн матриц ашиглан тодорхойлох юм. Магадлал болон үр дагаврын хэмжээг ашиглан эрсдэлээ үнэлснээр түүнд тохирсон эрсдэлийг удирдах, дотоод хяналтын хөтөлбөрийг авч хэрэгжүүлэх боломжтой.

Эрсдэл гарах магадлалыг үнэлэхдээ тухайн эрсдэлийн өмнө нь гарч байсан тохиолдол, давтамжийг судлан, ирээдүйд учрах магадлалыг таамаглан, дараах шалгуур асуултын дагуу магадлалыг тодорхойлж болно.

Магадлалын түвшин	Шалгуур асуулт	Эрсдэл гарах магадлал
1	<ul style="list-style-type: none"><li>Болох магадлал тун бага</li><li>Эрсдэл гарах магадлал 5%-иас бага</li><li>Онцгой нөхцөлд 1 удаа тохиолдож болзошгүй</li></ul>	Ховор
2	<ul style="list-style-type: none"><li>Жилд нэг удаа тохиолдох магадлал бага</li><li>Эрсдэл гарах магадлал 5%-25%</li><li>Ойрын 3 жилд тохиолдож болзошгүй</li></ul>	Бага
3	<ul style="list-style-type: none"><li>Жилд нэг удаа тохиолдох магадлалтай</li><li>Эрсдэл гарах магадлал 25%-60%</li><li>Ойрын 1 жилийн дотор тохиолдож болзошгүй</li></ul>	Болзошгүй
4	<ul style="list-style-type: none"><li>Хагас жилд заавал нэг удаа тохиолддог</li><li>Эрсдэл гарах магадлал 60%-90%</li><li>Ойрын 6 сарын хугацаанд тохиолдож болзошгүй</li></ul>	Өндөр
5	<ul style="list-style-type: none"><li>Улиралд заавал нэгээс дээш удаа тохиолддог</li><li>Эрсдэл гарах магадлал 90%-100%</li><li>Ойрын 1 сарын хугацаанд тохиолдож болзошгүй</li></ul>	Маш өндөр

Эрсдэлийн нөлөөллийг үнэлэхдээ тухайн эрсдэл үүссэн тохиолдолд гарах санхүүгийн болон санхүүгийн бус үр дагаврыг тодорхойлох бөгөөд дараах шалгуур асуултын дагуу нөлөөллийг тодорхойлж болно.

Нөлөөллийн түвшин	Шалгуур асуулт	Нөлөөллийн цар хэмжээ
1	<ul style="list-style-type: none"><li>Бодитой аливаа хохиролгүй</li><li>Нэр хүндийн эрсдэлгүй</li></ul>	Маш бага
2	<ul style="list-style-type: none"><li>Бодитой хохирол бага, санхүүгийн хохирлын хэмжээ 1.0 сая төгрөг хүртэл</li><li>Нэр хүндийн эрсдэл үүсэхгүй</li></ul>	Бага
3	<ul style="list-style-type: none"><li>Бодитой хохирол үүссэн, санхүүгийн хохирлын хэмжээ 1.0 сая төгрөгөөс – 10.0 сая төгрөг хүртэл</li><li>Нэр хүндийн эрсдэл тохиолдож болзошгүй</li></ul>	Дунд

4	<ul style="list-style-type: none"> <li>Бодитой хохирол үргэлжлэн илэрсэн, санхүүгийн хохирлын хэмжээ 10.0 сая төгрөгөөс – 100.0 сая төгрөг хүртэл</li> <li>Нэр хүндийн эрсдэл үүссэн</li> </ul>	Их
5	<ul style="list-style-type: none"> <li>Бодитой хохирлын хэмжээ их, санхүүгийн хохирлын хэмжээ 100.0 сая төгрөгөөс дээш</li> <li>Нэр хүндийн эрсдэл нэмэгдэж, олон нийтэд сөрөг мэдээлэл тархсан</li> </ul>	Ноцтой

Тухайлбал МҮЭ нь өөрийн нэг бүтээгдэхүүнийг МУТС-д ашиглагдах боломжтой бөгөөд ийм зорилгоор ашиглагдах магадлал өндөр, тухайн эрсдэл үүссэнээр гарах санхүүгийн хохирлыг тооцон үзэж гарах үр дагаврыг дунд гэж үнэлжээ. Магадлал, үр дагаврыг эрсдэлийн матрицын босоо, хэвтээ тэнхлэгт байрлуулан эрсдэлийн оноог тодорхойлоход өндөр эрсдэлтэй гэж гарч байна. Энэхүү өндөр эрсдэлд уялдсан урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Дараах эрсдэлийн матрицыг жишээ болгон үзүүлэв.

Зураг 1. Эрсдэлийн матриц

Тохиолдох магадлал	5 Маш өндөр	11	16	20	23	25
	4 Өндөр	7	12	17	21	24
	3 Болзошгүй	4	8	13	18	22
	2 Бага	2	5	9	14	19
	1 Ховор	1	3	6	10	15
		1 Маш бага	2 Бага	3 Дунд	4 Их	5 Ноцтой
<b>Үр дагавар</b>						
Эрсдэлийн үнэлгээ	<b>БАГА</b>	<b>ДУНД</b>	<b>ӨНДӨР</b>	<b>МАШ ӨНДӨР</b>		

#### Б. Төрөлх эрсдэл, эрсдэлийг удирдах арга хэрэгслийг үнэлэх

МУТС эрсдэлийг үнэлэх дараагийн арга нь МҮЭ-ийн үйл ажиллагаатай холбоотой дараах хүчин зүйлсийг авч үзэх юм. Үүнд:

- Төрөлх эрсдэл – Эрсдэлийг бууруулах арга хэрэгсэл, хяналтаас өмнө тухайн хүчин зүйл үүсэх эрсдэл;
- Эрсдэлийн хяналт – өөрийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг бууруулах, удирдахад чиглэсэн бодлого, журам, тогтолцоо, үйл ажиллагаа
- Үлдэгдэл эрсдэл – Төрөлх эрсдэлийг бууруулах хяналтыг авч хэрэгжүүлсний дараа үлдэж буй эрсдэл

*Төрөлх эрсдэл:* Төрөлх эрсдэлийг тодорхойлсноор МҮЭ өөрийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэхийн тулд нөөцийг хаана, юунд зарцуулахыг тодорхойлох боломжтой. Эрсдэлийг тодорхойлохдоо эрсдэлийн хүчин зүйл бүрийг тодорхойлж, тэдгээрийн түвшинг тогтоохдоо тоон болон чанарын мэдээллийг цуглуулна.

Харилцагчийн төрөл, газар зүйн байршил, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, харилцагчид хүргэх сувагтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлно. Үүний дараа дараах хүснэгтийг ашиглан эрсдэлийн түвшинд оноо өгнө.

Төрөлх эрсдэлийн түвшин	Тайлбар	Оноо
Маш өндөр	Өндөр - МҮЭ-ийн үйл ажиллагаа эсвэл үйлчлүүлэгчийн баазын дийлэнх хэсэг нь (90-100%) өндөр эрсдэлтэй гүйлгээ, үйл ажиллагаа, газарзүйн байршилтай холбоотой, эсвэл тодорхой эрсдэлтэй холбоотой олон тооны сэжигтэй гүйлгээний тайлан мэдүүлдэг	5
Өндөр	Дундаас бага зэрэг өндөр – МҮЭ-ийн үйл ажиллагаа эсвэл үйлчлүүлэгчийн баазын нэлээд хувь (60-90%) нь өндөр эрсдэлтэй гүйлгээ, үйл ажиллагаа, газарзүйн байршилтай холбоотой, эсвэл тодорхой эрсдэлтэй холбоотой дунджаас арай илүү тооны сэжигтэй гүйлгээний тайлан мэдүүлдэг	4
Дундаж	Дунд зэрэг – МҮЭ-ийн үйл ажиллагаа эсвэл үйлчлүүлэгчийн баазын дундаж хувь (25-60%) нь өндөр эрсдэлтэй гүйлгээ, үйл ажиллагаа, газарзүйн байршилтай холбоотой, эсвэл тодорхой эрсдэлтэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан дундаж тоогоор мэдүүлдэг	3
Бага	Дундаас бага - МҮЭ-ийн үйл ажиллагаа эсвэл үйлчлүүлэгчийн баазын дунджаас доогуур хувь (5-25%) нь өндөр эрсдэлтэй гүйлгээ, үйл ажиллагаа, газарзүйн байршилтай холбоотой, эсвэл тодорхой эрсдэлтэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан бага тоогоор мэдүүлдэг	2
Маш бага	МҮЭ-ийн үйл ажиллагаа эсвэл үйлчлүүлэгчийн баазын маш бага хувь (0-5%) нь өндөр эрсдэлтэй гүйлгээ, үйл ажиллагаа, газарзүйн байршилтай холбоотой, эсвэл тодорхой эрсдэлтэй холбоотой сэжигтэй гүйлгээний тайлан маш цөөн тоогоор мэдүүлдэг	1

*Эрсдэлийн хяналт:* Эрсдэлийг үр дүнтэй үнэлэхийн тулд МҮЭ нь тухайн эрсдэлийг хянах арга хэмжээ, тэдгээрийн үр дүнтэй байдал, үр нөлөөг үнэлэх хэрэгтэй. Эрсдэлийг удирдах тодорхой аргуудыг хууль, журамд тусгасан байдаг. Жишээлбэл:

- Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа
  - Эцсийн өмчлөгчийг тогтоох
  - УТНБЭ эсэхийг тогтоох
  - Харилцагч нь гуравдагч этгээдийг төлөөлж буй эсэхийг тогтоох
- Сэжигтэй гүйлгээ, сэжигтэй үйлдэл, бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэх
- Баримт бичгийг хадгалах
- МУТСТ сургалтын хөтөлбөр
- Комплаенсийн ажилтныг томилох, тэдгээрийн үүрэг хариуцлага

Эдгээр арга хэрэгслийг журам, хөтөлбөрт тусган батлуулсан байхаас гадна үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг мөн авч үзэх шаардлагатай. Тухайлбал тодорхой хугацааны интервалд (ихэвчлэн 12-24 сар) гарсан үйл ажиллагааны доголдол, дутагдлын тоогоор үр дүнтэй байдлыг хэмжиж болно.

Эрсдэлийн хяналтын чанарыг эрсдэлийн хүчин зүйл бүрээр үнэлэх ба дараах хүснэгтийг жишиг болгон ашиглаж болно.



Эрсдэлийн хяналтын чанар	Үзүүлэх үр нөлөө	Оноо
Маш хүчтэй	МҮЭ нь дээр дурьдсан хүчин зүйл бүрийг агуулсан МУТСТ албан ёсны бодлого журамтай. Бодлого нь удирдлага, ажилтнууд, комплаенсийн ажилтны үүрэг хариуцлагыг тодорхой агуулдаг. Удирдлага нь жил бүр дор хаяж нэг удаа бодлогыг хянаж, шинэчилж, шаардлагатай засваруудыг хийж, зөрчил илэрсэн үед засч залруулах арга хэмжээ авч буй эсэхийг хянадаг. Бодлогыг нарийн мөрддөг. Зөрчил гарах нь ховор, бага зэрэг бөгөөд цаг алдалгүй засч залруулдаг.	0.10 (90% эрсдэлийг бууруулна)
Хүчтэй	МҮЭ нь дээр дурьдсан хүчин зүйл бүрийг агуулсан МУТСТ албан ёсны бодлого журамтай. Бодлого нь удирдлага, ажилтнууд, комплаенсийн ажилтны үүрэг хариуцлагыг тодорхой агуулдаг. Удирдлага нь жил бүр дор хаяж нэг удаа бодлогыг хянаж, шинэчилж, шаардлагатай засваруудыг хийж, зөрчил илэрсэн үед засч залруулах арга хэмжээ авч буй эсэхийг хянадаг. Бодлогыг ихэнх тохиолдолд мөрдөж ажилладаг. Зөрчил гарах нь цөөн бөгөөд цаг алдалгүй засч залруулдаг.	0.30 (70% эрсдэлийг бууруулна)
Дундаж	МҮЭ нь дээр дурьдсан хүчин зүйл бүрийг агуулсан МУТСТ албан ёсны бодлого журамтай. Бодлого нь удирдлага, ажилтнууд, комплаенсийн ажилтны дийлэнх үүрэг хариуцлагыг тодорхойлсон. Удирдлага нь үе үе бодлогыг хянаж, шинэчилж, шаардлагатай засваруудыг хийж, зөрчил илэрсэн үед засч залруулах арга хэмжээ авч буй эсэхийг ихэнх тохиолдолд хянадаг. Бодлогыг ихэвчлэн мөрдөж ажилладаг. Зарим тохиолдолд зөрчил гардаг ба зөрчлийг ихэвчлэн засдаг боловч залруулах арга хэмжээ нь үргэлж шуурхай байдаггүй.	0.50 (50% эрсдэлийг бууруулна)
Сул	МҮЭ-д МУТСТ-тэй холбоотой албан ёсны бодлого журам байдаг боловч зөвхөн удирдлага, ажилтнууд, комплаенсийн ажилтны үүрэг хариуцлагыг ерөнхий байдлаар тодорхойлсон. Удирдлага нь үе үе бодлогыг хянадаг боловч шаардлагатай засвар өөрчлөлтийг бараг хийдэггүй. Бодлогын хэрэгжилт ерөнхийдөө дутмаг. Их хэмжээний зөрчил дутагдал гардаг ч засч залруулах арга хэмжээг удаан хийдэг.	0.70 (30% эрсдэлийг бууруулна)
Маш сул	Байгууллагад МУТСТ албан ёсны бодлогын баримт бичиг байхгүй.	1.00 (эрсдэлийг бууруулдаггүй)

Үлдэгдэл эрсдэл: Төрөлх эрсдэлийг бууруулах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа үлдэж буй эрсдэлийг үлдэгдэл эрсдэл гэнэ. Өөрөөр хэлбэл үлдэгдэл эрсдэл нь төрөлх

эрсдэл бүрийн оноо, түүний эсрэг авах хариу хяналтын арга хэмжээний онооны нийлбэр байх бөгөөд дараах томъёог ашиглаж болно.

$$\text{Төрөлх эрсдэл} \times \text{Хяналтын үр нөлөө} = \text{Үлдэгдэл эрсдэл}$$

Дараах бүтцийн дагуу үнэлж болно.

Төрөл	Төрөлх эрсдэл (1-5)	Эрсдэлийн үнэлгээний тайлбар	Бууруулах/Хяналтын арга хэмжээ	Үлдэгдэл эрсдэлийн оноо
<b>Харилцагчийн эрсдэл</b>				
Монгол улсын иргэн				
Гадаад улсын иргэн				
Нэрээ нууцлахыг хүссэн эсвэл өөрийн хэн болохыг баталж чадахгүй байгаа үйлчлүүлэгчид				
Улс төрд нөлөө бүхий этгээд				
Хэт нарийн төвөгтэй өмчийн болон хяналтын бүтэцтэй хуулийн этгээд				
Бэлэн мөнгө шаарддаг/ эрсдэлтэй салбар эсвэл бизнест үйл ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгчид				
Ашгийн бус байгууллага				
<b>Газарзүйн эрсдэл: Доорх улсаас ирсэн эсвэл эдгээр улстай бизнес эрхэлж буй үйлчлүүлэгчид</b>				
МУТСТ тогтолцоо хангалтгүй				
Санхүүгийн хориг, түүнтэй төстэй арга хэмжээнд орсон				
Авлига хээл хахууль эсвэл бусад гэмт хэрэг их хэмжээтэй				
Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлж, дэмждэг, нутаг дэвсгэртээ террорист байгууллага ажиллуулдаг				
Бусад "өндөр эрсдэлтэй" шинж чанарууд байгаа юу? (жишээлбэл, иргэдийн үймээн самуун гарах зэрэг) (тайлбарлах):				
<b>Бүтээгдэхүүн/үйлчилгээний эрсдэл</b>				
Хөрөнгө/Үл хөдлөх хөрөнгийн эрх шилжүүлэх				

Компани үүсгэн байгуулах/удирдах				
Траст үүсгэн байгуулах/удирдах				
Нэрлэсэн захирал, нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй холбоотой үйлчилгээ				
Харилцагчийн данс				
Харилцагчийн хөрөнгө удирдах				
Банк, хадгаламж, үнэт цаасны данс удирдах				
Компани үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдахад хувь нэмэр оруулах ажлыг зохион байгуулах				
Хуулийн этгээд үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах				
Бизнесийн байгууллагыг зарах, худалдан авах				
<b>Хүргэлтийн сувгийн эрсдэл</b>				
Зайнаас харилцагчид үйлчилгээ үзүүлэх жишээлбэл утас, видео дуудлага, имэйл ашиглах				
Санхүүжилтийн өөр платформоос мөнгө хүлээн авах, Жишээ нь, краудфандинг эсвэл виртуал хөрөнгө				
Гуравдагч этгээд эсвэл гадаад руу мөнгө илгээх/хүлээн авах				

Эрсдэлийн үнэлгээг эцэслэн, үлдэгдэл эрсдэлийг тодорхойлох: Эрсдэлийн үнэлгээний сүүлийн алхам нь тухайн МҮЭ-д тулгарч буй МУТСТ эрсдэлийн түвшин буюу Нийт үлдэгдэл эрсдэлийг тодорхойлох юм. Ингэхдээ (1) эрсдэлийн хүчин зүйл бүр дэх үлдэгдэл эрсдэлийг нэмж, (2) гарсан дүнг нийт эрсдэлийн хүчин зүйлийн тоонд хуваана. Дараах томъёог ашиглаж болно.

Эрсдэлийн хүчин зүйл бүр дэх үлдэгдэл эрсдэлийг нийлбэр ÷ Эрсдэлийн хүчин зүйлийн тоо = Нийт үлдэгдэл эрсдэл.

Гарсан тоонд үндэслэн дараах байдлаар үлдэгдэл эрсдэлийг тодорхойлно.

Үр дүн  
5 ба түүнээс бага, 4-өөс их  
4 ба түүнээс бага, 3-аас их  
3 ба түүнээс бага, 2-оос их

Нийт эрсдэл  
Маш өндөр  
Өндөр  
Дундаж

2 ба түүнээс бага, 1-ээс их

Бага

1 ба түүнээс бага

Маш бага

Эрсдэлийн үнэлгээний тайлбарыг дараах хүснэгтэд харуулав.

Түвшин	Тайлбар
Маш өндөр 5 ба түүнээс бага, 4-өөс их	МУТС үйл ажиллагаанд оролцох, эсвэл ийм үйл ажиллагаа явуулах магадлал өндөр, томоохон эрсдэлд анхаарал хандуулдаггүй, эрсдэлийн хяналт үр дүнтэй байдаггүй, эсвэл хяналтын үйл ажиллагаа нь үр дүнгүй байдаг.
Өндөр 4 ба түүнээс бага, 3-аас их	МУТС үйл ажиллагаанд оролцох, өртөх магадлал дунджаас дээгүүр, эсвэл холбогдох хяналтын үйл ажиллагаанд сул тал их байна. Томоохон эрсдэлийг үнэлээгүй, хяналт үр дүнтэй биш эсвэл хяналтын үйл ажиллагааны гүйцэтгэл нь хангалтгүй байж болно. Эрсдэлийн түвшинг хяналтын бодлого, үйл ажиллагаагаар бага зэрэг бууруулдаг.
Дундаж 3 ба түүнээс бага, 2-оос их	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох магадлал дунд зэрэг, эсвэл хяналтын үйл ажиллагаанд зарим сул тал бий. Эрсдэлийг ерөнхийд нь удирддаг бөгөөд холбогдох хяналт нь ерөнхийдөө үр дүнтэй байдаг ч тодорхой хэсгийг сайжруулах шаардлагатай байна. Эрсдэлийн түвшинг хяналтын үйл ажиллагааны тусламжтайгаар эрс багасгадаг.
Бага 2 ба түүнээс бага, 1-ээс их	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох нь бага. Эрсдэлийг ерөнхийд нь зөв удирдаж байгаа бөгөөд хяналт нь МУТС эрсдэлийн ихэнх хэсгийг үр дүнтэй бууруулдаг.
Маш бага 1 ба түүнээс бага	МУТС үйл ажиллагаанд өртөх, оролцох эрсдэл маш бага байна. Эрсдэлийг зохих ёсоор удирддаг бөгөөд хяналт нь МУТС эрсдэлийг үр дүнтэй бууруулдаг.

Эрсдэлийн үнэлгээний жишээ загварыг Хавсралт 1-т үзүүлэв.

#### **4. Эрсдэлийг удирдах арга хэрэгслийг тодорхойлох шат**

МҮЭ нь өөрийн харилцагч, санал болгож буй болон зах зээлд гаргах гэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүргэх суваг, болон өөрийн болон үйлчлүүлэгчдийн үйл ажиллагаа явуулж буй улс оронтой холбоотой үүсэх мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаар нарийн ойлголттой байх ёстой. Эдгээр эрсдэлтэй уялдсан бодлого, журмын хүрээнд харилцагчтай бизнесийн харилцаа тогтоох, таньж мэдэх, байнгын хяналт тавих үйл ажиллагааг явуулна.

Эрсдэлийг удирдах дотоод хяналтын хөтөлбөр нь МҮЭ-ийн МУТСТ комплаенсийн үйл ажиллагаа хэрхэн хийгдэхийг тодорхойлсон байх бөгөөд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, засаглал, сургалттай холбоотой асуудлыг нарийвчлан зохицуулна. Дотоод хяналтын хөтөлбөрт дараах асуудлуудыг заавал тусгана. Үүнд:

1. Өөрийн бизнесийн үйл ажиллагааны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал;
2. Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан, ердийн, нарийвчилсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журам;
3. Шинэ технологи болон өндөр эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохицуулалт;
4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, төрийн болон олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалт;

5. сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, хадгалах журам;
6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;
7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөр;

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

**/Байгууллагын нэр/ мөнгө угаах, терроризмыг  
санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ 20... он**

Эрсдэлийн үнэлгээний баримт бичиг	
Эрсдэлийн үнэлгээний тайланг бэлтгэсэн:	
Албан тушаал:	
Он сар өдөр:	
Танилцаж баталсан:	
Албан тушаал:	
Он сар өдөр:	

**1. Ерөнхий мэдээлэл**

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, “Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар бүлэгт заасны дагуу энэхүү мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэв.

**2. Үйл ажиллагааны товч мэдээлэл**

*Өөрийн байгууллагын явуулж буй үйл ажиллагааны талаарх товч мэдээллийг оруулна. Тухайлбал байгууллагын бүтэц, санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж буй харилцагчдийн төрөл, харилцагчдын болон өөрийн үйл ажиллагаа явуулж буй газар зүйн бүс нутаг болон бусад холбогдох мэдээлэл орно.*

**2.1. Эрсдэлийн үнэлгээний зорилго**

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлд суурилсан зарчмаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулах үндсэн зорилготой.

**2.2. Эрсдэлийн үнэлгээ**

**Үйлчилгээ үзүүлж буй харилцагчдын төрөл: (Бүх хамаарах төрлийг сонгох)**

- Хувь хүн
- Хуулийн этгээд, ашгийн буй байгууллага
- Монгол улсын иргэн, оршин суугч
- Оршин суугч бус (хувь хүн эсвэл хуулийн этгээд)
- Зайнаас үйлчилгээ үзүүлсэн харилцагч (жишээ нь утас, интернетээр)
- Байнгын үйлчлүүлэгч
- Байнгын бус үйлчлүүлэгч

- Улс төрд нөлөө бүхий этгээд
- Өндөр эрсдэлтэй улсад үйл ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгч
- Нэрээ нууцлахыг хүссэн эсвэл өөрийн хэн болохыг баталж чадахгүй байгаа үйлчлүүлэгчид
- Нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй, нэрлэсэн хувьцаа гаргадаг эсвэл хэт нарийн төвөгтэй өмчийн болон хяналтын бүтэцтэй хуулийн этгээд
- Гадаадын аж ахуйн нэгжүүд, ялангуяа газарзүйн эрсдэл өндөртэй байршилд байрладаг оффшор компаниуд (халхавч компаниуд гэх мэт)
- Бэлэн мөнгө их эргэлддэг бизнес (жишээлбэл, дэлгүүр, ресторан, жижиглэнгийн дэлгүүр, архины дэлгүүр, тамхи борлуулагч, хувийн АТМ, автомат машины оператор, зогсоол гэх мэт)
- Ашгийн бус болон буяны байгууллага (гадаад болон дотоод)
- Бусад (тайлбарла):

- Тийм гэж сонгосон төрөл бүрийн хувьд:
  - Нийт харилцагчийн хэдэн хувийг тухайн төрлийн харилцагч эзэлж байна вэ?
  - Нийт харилцагчийн дунджаар хэдэн хувийг тухайн төрлийн харилцагч эзэлж байна?
  - Тухайн харилцагчийн хийсэн гүйлгээ эсвэл бизнесийн хэмжээ ойролцоогоор хэд вэ?

## Газар зүйн эрсдэл

Танайд дараах төрлийн харилцагч байдаг уу?

- Бусад улсад байрладаг эсвэл үйл ажиллагаа явуулдаг  Тийм  Үгүй
- Бусад улс руу мөнгө илгээдэг  Тийм  Үгүй
- Бусад улсаас мөнгө хүлээн авдаг?  Тийм  Үгүй

Аль нэг асуултанд “Тийм” гэж хариулсан бол:

- Үйлчлүүлэгчдийн хэдэн хувь нь ийм ангилалд багтдаг вэ??
- Ийм үйлчлүүлэгчдийн хийсэн гүйлгээ, бизнесийн хэмжээ ойролцоогоор хэд вэ?

Аль нэг асуултанд “Тийм” гэж хариулсан бол найдвартай эх сурвалжаас эдгээр улсууд дараах ангилалд ордог эсэхийг тодруулна уу: *(Тохирох хариултыг бүгдийг сонгох)*

МУТСТ тогтолцоо хангалтгүй юу?

Санхүүгийн хориг, түүнтэй төстэй арга хэмжээнд орсон уу?

Авлига хээл хахууль эсвэл бусад гэмт хэргийн түвшин өндөр үү?

Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлж, дэмждэг, нутаг дэвсгэртээ террорист байгууллага ажиллуулдаг уу?

Бусад "өндөр эрсдэлтэй" шинж чанарууд байгаа юу? (жишээлбэл, иргэдийн үймээн самуун гарах зэрэг) (тайлбарла):

- Танай үйл ажиллагааны ойролцоогоор хэдэн хувь нь дээрх ангилалд хамаарах улсуудын хүрээнд бизнес эрхэлдэг эсвэл гүйлгээ хийдэг үйлчлүүлэгчидтэй холбоотой вэ?
- Эдгээр үйлчлүүлэгчдийн хийсэн гүйлгээ эсвэл бизнесийн хэмжээ ойролцоогоор хэд вэ?
- Холбогдох ангилал тус бүрийн хувьд эрсдэлийн хүчин зүйлсийг анхаарч, бууруулахын тулд танай байгууллага ямар хяналтын арга хэмжээ авдаг вэ?

### **Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл**

Танай байгууллага ямар төрлийн үйлчилгээ үзүүлдэг вэ? *(хамаарах бүх хариултыг сонгох)*

Үл хөдлөх худалдах, худалдан авах

Харилцагчийн хөрөнгө удирдах

Хуулийн этгээд үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах

Траст үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах

Нэрлэсэн этгээдээр ажиллах

Банк, хадгаламж, үнэт цаасны данс удирдах

Компани үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдахад хувь нэмэр оруулах ажлыг зохион байгуулах

Бизнесийн байгууллагыг зарах, худалдан авах

Сонгосон төрөл бүрийн хувьд:

- Танай үйл ажиллагааны ойролцоогоор хэдэн хувь нь ийм ангилалд багтдаг вэ?



- Эдгээр ангиллын үйл ажиллагаагаар үүсгэсэн гүйлгээ, бизнесийн хэмжээ ойролцоогоор хэд вэ?

### Хүргэлтийн сувгийн эрсдэл

Танай байгууллага үйлчилгээгээ хэрхэн үзүүлдэг вэ?

- Биечлэн
- Зайнаас (интернет, утас г.м)

Дээрх төрөл тус бүрийн хувьд:

- Энэ ангиллын үйлчлүүлэгчид танай үйлчлүүлэгчдийн хэдэн хувийг бүрдүүлдэг вэ?
- Эдгээр ангилал тус бүрээр үйлчлүүлэгчдийн үүсгэсэн гүйлгээ эсвэл бизнесийн хэмжээ ойролцоогоор хэд вэ?
- Эрсдэлийн хүчин зүйлсийг арилгах, багасгахын тулд танай байгууллага ямар хяналтыг бий болгосон бэ?

Танай байгууллага харилцагчийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөр илгээдэг, эсвэл хүлээн авдаг уу?

- Хэрэв тийм бол эдгээр ангиллын аль нэгэнд хамаарах байгууллагын харилцагчийн данс руу орж/гарж буй гүйлгээний хэмжээ хэд вэ?

Танай байгууллага бизнесийн шинэ үйл ажиллагаа явуулж эхэлсэн эсвэл өмнө нь ажиллаж байгаагүй шинэ салбарт үйл ажиллагаа явуулахаар шилжихээр төлөвлөж байна уу?

- Хэрэв тийм бол бизнесийн шинэ чиглэлүүд юу вэ?

### 2.3. Эрсдэлийн дүн шинжилгээ

Төрөл	Төрөлх эрсдэл (1-5)	Эрсдэлийн үнэлгээний тайлбар	Бууруулах/Хяналтын арга хэмжээ	Үлдэгдэл эрсдэлийн оноо
<b>Харилцагчийн эрсдэл</b>				
Монгол улсын иргэн				
Гадаад улсын иргэн				
Нэрээ нууцлахыг хүссэн эсвэл өөрийн хэн болохыг баталж чадахгүй байгаа үйлчлүүлэгчид				
Улс төрд нөлөө бүхий этгээд				

Хэт нарийн төвөгтэй өмчийн болон хяналтын бүтэцтэй хуулийн этгээд				
Бэлэн мөнгө шаарддаг/ эрсдэлтэй салбар эсвэл бизнест үйл ажиллагаа явуулдаг үйлчлүүлэгчид				
Ашгийн бус байгууллага				
...				
<b>Газарзүйн эрсдэл: Доорх улсаас ирсэн эсвэл эдгээр улстай бизнес эрхэлж буй үйлчлүүлэгчид</b>				
МУТСТ тогтолцоо хангалтгүй				
Санхүүгийн хориг, түүнтэй төстэй арга хэмжээнд орсон				
Авлига хээл хахууль эсвэл бусад гэмт хэрэг их хэмжээтэй				
Терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлж, дэмждэг, нутаг дэвсгэртээ террорист байгууллага ажиллуулдаг				
Бусад "өндөр эрсдэлтэй" шинж чанарууд байгаа юу? (жишээлбэл, иргэдийн үймээн самуун гарах зэрэг) (тайлбарлах):				
...				
<b>Бүтээгдэхүүн/үйлчилгээний эрсдэл</b>				
Хөрөнгө/Үл хөдлөх хөрөнгийн эрх шилжүүлэх				
Компани үүсгэн байгуулах/удирдах				
Траст үүсгэн байгуулах/удирдах				
Нэрлэсэн захирал, нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй холбоотой үйлчилгээ				
Харилцагчийн данс				
Харилцагчийн хөрөнгө удирдах				
Банк, хадгаламж, үнэт цаасны данс удирдах				
Компани үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдахад хувь нэмэр				

оруулах ажлыг зохион байгуулах				
Хуулийн этгээд үүсгэн байгуулах, ажиллуулах, удирдах				
Бизнесийн байгууллагыг зарах, худалдан авах				
...				
<b>Хургэлтийн сувгийн эрсдэл</b>				
Зайнаас харилцагчид үйлчилгээ үзүүлэх жишээлбэл утас, видео дуудлага, имэйл ашиглах				
Санхүүжилтийн өөр платформиос мөнгө хүлээн авах, Жишээ нь, краудфандинг эсвэл виртуал хөрөнгө				
Гуравдагч этгээд эсвэл гадаад руу мөнгө илгээх/хүлээн авах				
...				

#### 2.4. Эрсдэлийн нэгдсэн үнэлгээ

Эрсдэлийн оноо (Эрсдэлийн хүчин зүйл бүр дэх үлдэгдэл эрсдэлийг нийлбэр ÷ Эрсдэлийн хүчин зүйлийн тоо)	
Эрсдэлийн түвшин	<b>МАШ ӨНДӨР / ӨНДӨР / ДУНДАЖ / БАГА / МАШ БАГА</b>